

БАЙГУУЛЛАГЫН ИЛ ТОД БАЙДЛЫН 2021 ОНЫ БҮТЭН
ЖИЛИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,
ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН

2021 оны 12 дугаар сарын 22

Улаанбаатар хот

Байгууллагын ил тод байдлын 2021 оны хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн ажлын тайланг танилцуулж байна. Үүнд:

1. Эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэл болон тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүн, зохион байгуулалтын бүтцийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх ажлын хэрэгжилт:

Тус байгууллагын www.sport.ub.gov.mn, www.ub.sport.gov.mn цахим хуудсуудаар хэрэглэгчдийн дунд үйл ажиллагааны нээлттэй байдал, хэрэгжүүлсэн ажил, мэдээ мэдээллийг тогтмол оруулж хэвшлээ. 2021 оны жилийн эцсийн байдлаар байгууллагын цахим хуудсуудад давхардсан тоогоор 159960 зочин зочилж, Facebook хуудсанд 4528 дагагчтай, үйл ажиллагааны чиглэлээр 350 мэдээлэл оруулж, 94.282 иргэдэд хүргэсэн. Мөн байгууллагаас үзүүлж буй үйлчилгээ, үйл ажиллагааны мэдээлэл, хүний нөөц, төсөв санхүүгийн мэдээллийг цаг тухайд нь шинэчлэн байгууллагын <http://sport.ub.gov.mn> вэб сайтын мэдээллийн санд тогтмол байршуулж, мэдээллийг цахим хэлбэрээр тогтмол үзүүлж олон нийтэд хүргэж байна. Тайлант хугацаанд байгууллагын даргын “А” тушаал 26, “Б” тушаал 16 гарсныг цахим хуудсанд байршуулсан. <http://sport.ub.gov.mn> вэб сайтын мэдээллийн санд тогтмол байршуулж, мэдээллийг цахим хэлбэрээр тогтмол үзүүлж олон нийтэд хүргэж ажилласан тул 100 хувьтай гэж үнэллээ.

2. Үйлчилгээ, захидал харилцааны асуудал хариуцсан албан хаагчийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, албан тушаал, ажиллах журам, харилцах утас, иргэдийг хүлээн авч уулзах цагийн хуваарийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх ажлын хэрэгжилт:

Байгууллагын ажилтан, албан хаагчдын холбогдох мэдээллүүдийг байгууллагын мэдээллийн самбар, цахим хуудсанд тогтмол байрлуулан, тухай бүрт шинэчлэн ажиллаж байна. Мөн байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөө болон 2021 оны 06 дугаар сарын 14-ний өдрийн А/15 дугаар тушаалаар батлагдсан “Хөдөлмөрийн дотоод журам”, цаг үеийн шинж чанартай мэдээ, мэдээллийг цахим хуудас болон мэдээллийн самбарт тухай бүр байршуулсан.

Иргэдтэй хийх уулзалтын хуваарийг батлан, 2021 онд нийт 15 иргэнтэй уулзаж 2 асуудлыг дээд шатны байгууллагад уламжлан, бусад асуудлыг байгууллагын хэмжээнд шийдвэрлүүлэн ажилласан тул 100 хувьтай гэж үнэллээ.

3. Үйлчилгээ авахад шаардагдах бичиг баримтын жагсаалтыг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх ажлын хэрэгжилт:

Нийслэлийн Спортын хорооноос 2021 онд иргэдэд чиглэсэн цахим гүйлт, “Ковид-19” цар тахлаас сэргийлэх QR код, түр журмын хэрэгжилтийг хангах хяналтын ажил, хүний нөөцийн чадавхийг сайжруулах сургалт, дархлаа дэмжих дасгал хөдөлгөөн, өсвөрийн шигшээ багийн онлайн хичээл, Нийслэлийн иргэдийн спортын наадам, Нийслэлийн нутгийн захиргааны наадам гэх мэт үйл ажиллагаатай холбогдолтой батлагдсан удирдамж, заавар зэрэг 315 мэдээллийг www.sport.ub.gov.mn цахим хуудас, ub.sport.gov.mn дэд хуудсан, фэйсбүүк пэйж хуудас болон мэдээллийн самбарт байршуулж ажилласан тул 100 хувьтай гэж үнэллээ.

4. Үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж, дүрэм, журам, зааврыг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх ажлын хэрэгжилт:

Нийслэлийн Спортын хорооны үйл ажиллагаанд мөрдөгдөж байгаа Биеийн тамир, спортын тухай хууль, холбогдох бусад 13-н хууль, УИХ-ын 1 тогтоол, Засгийн газрын 12 тогтоол, НИТХ-ын 4 тогтоол, НЗД-ын 18 захирамж, дүрэм, зааврыг байгууллагын www.sport.ub.gov.mn цахим хуудас, ub.sport.gov.mn дэд хуудасны “Хууль, эрх зүй” цэсэнд болон мэдээллийн самбартаа тухай бүр байршуулж ажилласан тул 100 хувьтай гэж үнэллээ.

5. Шинээр боловсруулж байгаа бодлогын баримт бичиг болон захиргааны хэм хэмжээний актын шийдвэрийн төслийг цахим хуудсандаа 30-аас доошгүй хоног ойлгомжтой байдлаар байрлуулж, холбогдох төрийн ба төрийн бус байгууллага, мэргэжлийн шинжээч, эрдэмтэн, иргэдийн саналыг авах, үндэслэлтэй гэж үзвэл уг саналыг төсөлд тусгах;

“Шилэн дансны тухай” хууль, Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох” журамд заасны дагуу тайлант хугацаанд багтаан www.shilendans.gov.mn вэб сайт болон байгууллагын шилэн данс болон мэдээллийн самбарт шинээр боловсруулж байгаа “Нийслэлийн Спортын хорооны стратеги төлөвлөгөө”, “Байгууллагын 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө”, “Нийслэлийн хөгжлийн 2022 оны төлөвлөгөө” зэргийг байгууллагын цахим хуудас болон пэйж хуудсанд байршуулсан бөгөөд бусад бодлогын баримт бичгүүдийн төслийг байршуулаагүй байгаа тул 70%-тай гэж үнэллээ.

6. Үзүүлж байгаа үйлчилгээний арга, хэлбэрийг боловсронгуй болгох зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлэх ажлын хэрэгжилт:

Коронавируст /Ковид-19/ цар тахалтай үед спортын сургалт, дасгалжуулалтыг тасралтгүй явуулах арга хэмжээний хүрээнд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө гарган хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Төлөвлөгөөний дагуу 2021 оны 12 дугаар сарын 22-ны байдлаар иргэдийн дархлааг дэмжих дасгал хөдөлгөөний 557 удаагийн хичээлийг Дүүргүүдийн биеийн тамир, спортын хороодтой хамтран цахим хэлбэрээр зохион байгуулж байгууллагын sport.ub.gov.mn цахим хуудас, биеийн тамир, спортын салбарын цахим мэдээллийн сангийн ub.sport.gov.mn дэд сайт, “Нийслэлийн спортын хороо” пэйж хуудас, дүүргүүдийн биеийн тамир, спортын хороодын facebook групп болон пэйж хуудсуудаар дамжуулан 202.965 хүнд хүргээд байна.

Мөн дүүргүүдийн Засаг даргын дэргэдэх өсвөрийн шигшээ багуудын цахим сургалтуудыг 2021 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн тасралтгүй явуулж байна. 2021 оны 12 дугаар сарын 22-ны байдлаар өсвөрийн шигшээ багуудын 532 удаагийн цахим хичээлийг “Нийслэлийн спортын хороо” пэйж хуудсан болон Дүүргүүдийн биеийн тамир, спортын хороодын facebook групп болон пэйж хуудсуудад байршуулан 116.862 хүнд хүргэж ажилласан тул 100 хувьтай гэж үнэллээ.

7. Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу төрийн байгууллагын гүйцэтгэх тодорхой чиг үүргийг төрийн бус байгууллага гүйцэтгэж байгаа тохиолдолд тухайн төрийн бус байгууллагын нэр, хаяг, цахим хуудас, эрхэлж байгаа үйл ажиллагааны чиглэлийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан мэдээлэх ажлын хэрэгжилт:

Улсын Онцгой комиссын даргын 2021 оны 41 дүгээр тушаал, 25 дугаар хуралдааны шийдвэрийн дагуу үзэгчгүйгээр тэмцээн, уралдаан зохион байгуулах нөхцөлийг бүрдүүлж спортын 21 холбоотой “Хариуцлагын гэрээ” байгуулан 9 дүүргийн биеийн тамир, спортын хороодтой хамтран халдвар хамгааллын дэглэмийг мөрдүүлж ажилласан. Улаанбаатар хотын аварга шалгаруулах дугуйн тэмцээнийг Монголын Дугуйн холбоогоор, байт харвааны тэмцээнийг Монголын Байт харвааны холбоогоор, “Цахим гимнастрада” бүх нийтийн биеийн арга хэмжээг Монголын Шугаман бүжгийн холбоогоор, “Цахим гүйлт”, “Эрүүл мэндийн гүйлт” зэрэг арга хэмжээг зохион байгуулах ажлыг Монголын хөнгөн атлетикийн холбоогоор, “Грассрүүтс” нийтийн хөл бөмбөгийн сургалтыг Монголын хөл бөмбөгийн холбоогоор, Дэлхийн уламжлалт спорт, тоглоомын олон улсын өдөрт зориулсан үндэсний их сурын Төвийн бүсийн чуулга харвааны тэмцээнийг Монголын Үндэсний харваачдын холбоогоор, Мастер ангилалын тамирчдын тэмцээнийг “Их талын

дуулиан” ТББ болон Монголын Хөлбөмбөгийн холбооны ахмадын зөвлөлөөр тус тус гүйцэтгүүлж, 6-н спортын холбооны нэр, хаяг, цахим хуудас, эрхэлж байгаа үйл ажиллагааны чиглэлийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан мэдээлсэн тул 100% гэж үнэллээ.

8. Тухайн байгууллага тодорхой төрлийн аж ахуйн үйл ажиллагаа эсхүл бусад үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгодог бол тухайн зөвшөөрөл эзэмшигчийн нэр, хаяг, эрхлэх үйл ажиллагааны чиглэл, зөвшөөрөл олгосон болон дуусгавар болох хугацааг цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх ажлын хэрэгжилт:

Манай байгууллагад ямар нэг үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгодоггүй тул энэхүү ажлын хэрэгжилтийг үнэлээгүй болно.

9. Салбарын хэмжээнд улсын төсвийн хөрөнгөөр болон гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, явц, байдлын талаарх мэдээллийг цахим хуудсандаа байрлуулан тухай бүр шинэчлэх ажлын хэрэгжилт:

Биеийн тамир, спортын салбарын хэмжээнд улсын төсвийн хөрөнгөөр баригдаж байгаа Нийслэл болон Чингэлтэй, Баянгол, Баянзүрх, Налайх, Сүхбаатар дүүргүүдийн спорт цогцолборын 6 барилгын ажлын явц, Шинээр ашиглалтад орсон Мөсөн ордон, Баянхошуу, Шархад, Дамбадаржаа дэд төвүүдэд шинээр баригдах спорт цогцолборуудтай холбогдолтой мэдээллийг байгууллагын цахим хуудсандаа байршуулж ажилласан тул 90%-тай үнэллээ.

Байгууллагын ил тод байдлын 2021 оны үйл ажиллагааг Монгол улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6.2.1, 6.2.2-т заасан аргачлалын дагуу тооцож, зорилт, арга хэмжээний дундаж үнэлгээгээр хэрэгжилтийг тус журмын 6.2.3 дахь заалтын дагуу шилжүүлэн тооцож 95 хувьтай буюу “Тодорхой үр дүнд хүрсэн” гэж үнэллээ.

ХЯНАСАН:
НИЙСЛЭЛИЙН СПОРТЫН ХОРООНЫ
ДАРГА

Ж.ГАНБОЛД

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:
ӨСВӨР ҮЕ, ЗАЛУУЧУУДЫН СПОРТ, СУРГАЛТ
ДАСГАЛЖУУЛАЛТ, ШИГШЭЭ БАГИЙН АСУУДАЛ
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН

Г.БЯМБАСАЙХАН